

Сургуулийн дүрэм

„ БҮХ ХҮН ШИЛДЭГ САЙН БАЙХ БОЛОМЖГҮЙ, ХАРИН БҮХ ХҮН АМЖИЛТТАЙ БАЙЖ БОЛНО“

Сургуулийн журамд сургуулийн бүх хүүхэд, сурагч (цаашид "сурагч" гэх мэт), тэдний хууль ёсны төлөөлөгчид заавал дагаж мөрдөх, хичээлийн цагт, өдөр өнжүүлэх болон сургуулийн клубт байх, эсвэл сургуулиас гадуур болон бусад газраас зохион байгуулдаг нэмэлт арга хэмжээний үеэр заавал дагаж мөрдөнө.

Сургуулийн дүрмийг тодорхойлсон журам нь бүх хүмүүст аюулгүй орчныг бүрдүүлэхэд тусалдаг бөгөөд ингэснээр харилцан хамтын ажиллагаа нь хүндэтгэл, хүлээцтэй байдал, нээлттэй харилцааны зарчимд суурилдаг.

1 Сургуулийн дэглэм

1. Сургууль өглөө 7:00 цагт хичээлтэй сурагчдад 6:50 цагт хаалга нээнэ. Бусад сурагчдыг 7:40 цагт сургууль руу оруулдаг. Сурагчид сургууль дээрээ хичээл эхлэхээс 5 минутын өмнө ангидаа ирсэн байх ёстой, энхий 1-р цаг эхлэхээс өмнө ангидаа орж хичээлдээ бэлтгэнэ. Сурагчид сургуулийн III- хэсэгт байрлуулсан хажуугийн хаалгаар дамжин хувцасны өрөөнд орж ирдэг, дунд нь орох хаалгаар дамждаг (холбосон коридороор). Хичээл явагдаж байх үеэр сургуульд ирвэл (жишээ нь, эмчээс буцаж ирэхэд) тэд үүдний гол хаалгаар (I хэсэг/павельон) дамжина.
2. Хичээлийн 1 цаг 45 минут байдаг, тэдгээрийг сурган хүмүүжүүлэх ажилтнууд эхлүүлж, төгсгөдөг. Хичээл эхлэх цаг:

0. цаг	1. цаг	2. цаг	3. цаг	4. цаг	5. цаг	6. цаг	7. цаг	8. цаг
7. 00	8. 00	8. 55	10. 00	10. 55	11. 50	12. 45	13. 40	14. 35

3. Сургуулийн захирлын баталсан хуваарийн дагуу хичээлийг заадаг, аливаа өөрчлөлтийг цаг тухайд нь мэдээллэж, сургуулийн вэбсайт дээр нэгэн зэрэг цахим сурагчийн дэвтэрт (цаашид eЖК) байршуулдаг.
4. Спортын үйл ажиллагааг зөвхөн тэмдэглэгдсэн талбайд, тодорхой цагт хийх боломжтой бөгөөд сурагчид тогтоосон дүрэм зааврыг дагаж мөрдөх шаардлагатай.
5. Үдийн цайны завсарлагааны үеэр сурагчид сургуулиас гардаг (сургууль хяналт тавьдаггүй). Сурагчид театрын урд байхдаа сургуулийн удирдлагын хяналтанд байна. Сурагчид сургууль руу манаачтай гол хаалгаар орох бөгөөд хяналтын зааврыг дагаж мөрдөнө.
6. Хичээлийн дараа сурагчид анги танхимаа цэвэрлэж, дараа нь багшийн хамт хувцасны өрөөнд очно. Тэд сурагчдыг сургуулиас гарахыг зохицуулана. Өдөр өнжихөд очих сурагчдыг сурган хүмүүжүүлэгчид эсвэл өдөр өнжихийн багш нар хүлээн авч дагуулан явна.
7. Сурагчид ангиас гарсны дараа сурган хүмүүжүүлэх ажилтан ангийг түгжинэ.
8. Үдээс хойшхи үйл ажиллагааг (давтлага, хичээл, дугуйлан, г.м.) хариуцсан багш нь хариуцана.

2 Сургуульд явах

1. Боловсролын тухай хуулийн 36-р хэсэгт зааснаар сурагч есөн жилийн хугацаанд заавал сургуульд хамрагдах ёстой.

2. Сурагч нь сургуульд сурч, зохих боловсрол эзэмших, цагийн хуваарийн дагуу хичээлд оролцох, сургуулийн дүрэм журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.
3. Сурагчдын хууль ёсны төлөөлөгчид хүүхдийг сургуульд хамруулах үүрэгтэй.
4. Сурагчдыг хичээлээс чөлөөлөх асуудлыг дараах зарчмаар удирддаг:
 - a. Сурагч сургуульдаа яваагүй шалтгаан нь зөвхөн өвчтөй байх, эсвэл чухал гэр бүлийн асуудлаас болсон шалтгаан байх ёстой, энэхүү шалтгааныг заавал сурагчийн дэвтэр дээр бичин эцэн эх нь гарын үсэг зурж батлана.
 - b. Хүүхдийг хичээлээс чөлөө авахад эхлээд урьдчилан ангийн багшид нь мэдэгдэнэ, ангийн багш нэг өдрийн чөлөө өгөх эрхтэй, удаан хугацаагаар авах чөлөөг сургуулийн захирал эсвэл захиралын хууль ёсны орлогч шийднэ, өрөгдлийг бичгээр гаргана.
 - c. Гэнэтийн асуудлаас болон урьдчилан мэдээллэх боломжгүй (өвдөх, гэр бүлийн гэнэтийн асуудал гэх мэт), үед хүүхдийн хууль ёсны хариуцагчид з хоногийн дотор ангийн багшид шалтгаанаа мэдээлэнэ, сурагч сургуульдаа ирэхдээ сурагчын дэвтэр дээр чөлөөний шалтгааныг бичсэн (гарын үсгээ зурж бататгасан байх), хэрэв үүнийг хийгээгүй бол хичээл тасалсан гэж үзнэ.
 - d. Сургуулиас янз бүрийн шалтгаанаар хичээлд ирдэггүй бол (байнга хичээл тасалдаг) дээд байгууллагтай хамтран ажиллана, давхар хоёр дахин баталгаажуулах, баримт бичиг шаардана, хүүхдийн хууль ёсны хариуцагч нар энэ шалтгааныг нотлох болно,
 - e. Эмч рүү явах үед хичээлээс нь заавал хүүхдийн эцэг эх нь ирж авна эсвэл өөрийг нь явах зөвшөөрлийг бичгээр өгнө, сургууль дээрх гэнэтийн асуудлыг сургууль өөрөө зохицуулна.

3 Сургуульд байх үед сурагчийн эрх үүрэг, хүүхдийн хууль ёсны асран хамгаалагчийн эрх үүрэг болон сургуультай хамтран ажиллах журам

3.1 Сурагчдын эрх

1. Сурагч бүрийн эрх:
 - a. сургуулийн боловсролын програмын дагуу сурагч боловсрол эзэмших эрхтэй „Хүн бүлгөн шилдэг сайн байх боломжгүй харин бүгд амжилттай байж болно“,
 - b. бүх мэдээллийг чөлөөтэй авах боломжийг олгоно, тэдний оюун санааны, ёс суртахууны ба нийгмийн хөгжлийг дэмжинэ,
 - c. тэдний ёс суртахуун болон оюун ухаанд муугаар нөлөөлөх мэдээллээс хамгаалах,
 - d. бүх зүйлд өөрийн гэсэн асуудалд санал бодлоо илэрхийлэх эрхтэй, ялангуяа шударга ёсны зарчимтай зөрчилдөх зүйлийг ангийн багшид эсвэл бусад хичээлийн багшид, эсвэл сурган хүмүүжүүлэх ажилчид (боловсролын зөвлөх багш, урьдчилан сэргийлэх арга зүйн багш), сургуулийн захиралд эсвэл захиралын орлогчид мэдээллэх хэрэгтэй, эсвэл итгэлцлийн хайрцагт хийх (schrankaduver@zs-spacak.cz),
 - e. бие махбодийн болон сэтгэцийн хүчирхийллээс хамгаалах, хайхрамжгүй хандах, нийгэмшил – эмгэг судлалын үзэгдэл гаргах, ялгаварлан гадуурхах (яс үндсээр, хэл, арьс өнгөөр, хэл, шашин шүтлэгээр гэх мэт),
 - f. хэрэв өөрөө асуудалтай тулгарвал эсвэл нэг асуудал гарвал тусламж үзүүлэх ёстой,
 - g. хичээлийг ойлгохгүй, эсвэл өөрийн мэдлэгийг дээшлүүлэхэд хэрэгтэй зүйлийг сурган хүмүүжүүлэгчээс тусламж авах эрхтэй,

- h. чухал шалтгаантай үед тусламж үзүүлэх (хүнд өвчтэй нөхцөлд, эрүүл мэндийн тахир дутуу, гоц авьяастай),
- i. сургуулийн зөвлөгөө өгөх үйлчилгээтэй,
- j. эрүүл орчинд амьдрах ба ажиллах,
- k. хар тамхи болон мансуурах бодисноос хамгаалах,
- l. сурагч өөрөө удирдах ажилд оролцох эрхтэй, сонгогдох эрхтэй, асуулт, санал шүүмжил тавих эрхтэй,
- m. амрах ба чөлөөт цагаар, завсарлагаанаар бусдад саад болохгүйгээр гар утсыг хэрэглэж болно.

3.2 Хууль ёсны асран хамгаалагч – эцэг эх

1. Сурагчийн хууль ёсны асран хамгаалагч бол сургуулийн чухал нөхөр, түүнийг орлох хэнч байхгүй мөн тэд нарт тэдний хүүхэдтэй холбоотой бүх мэдээллийг сургууль өгөх үүрэгтэй, тэд мэдээллийг авах эрхтэй. Сургууль болон сурагчийн хууль ёсны асрын хамгаалагчийн харьцах гол зүйл бол цахим сурагчийн дэвтэр юм.
2. Өөрийн хүүхдийн сурлагийн талаар байнга мэдээлэл авах эрхтэй, мөн түүний сахилага бат, үүргээ биелүүлж байгаа эсхийг мэдэх эрхтэй.
3. Хэрэв хүүхдийн эрх ямар нэгэн хэмжээгээр зөрчигдсөн гэж үзэж байгаа бол хүүхдийн хууль ёсны хариуцагч түүнийг нэхэмжлэх эрхтэй. Сургуулийн захирал, сурган хүмүүжүүлэх ажилтнууд сурагчийн хууль ёсны асран хамгаалагчдаас ирүүлсэн санал, хүсэлтэд боломжийн бөгөөд зохих ёсоор, богино хугацаанд хариу өгөх үүрэгтэй.
4. Хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч нь сургуулийн зөвлөх ажилтнуудаас (боловсролын зөвлөх, урьдчилан сэргийлэх арга зүй, тусгай багш) мэргэжлийн туслалцаа авах эрхтэй.

3.3 Сурагчийн сахилга бат ба үүрэг

1. Сурагчийн үүрэг:
 - a. сурагч сургуульдаа тогмол явах ба хичээлийн хувиарийн дагуу хичээлдээ сурах ёстой,
 - b. бүх сургуулийн ажилчидтай эелдэг харьцах, хүндэтгэлтэй хандах, мэндэлж тэдний заавар зөвлөгөөг дагана,
 - c. зохистой, цэвэрхэн хувцаслах сургуульд заавал таавчиг өмсөнө,
 - d. сургуульд болон ойр орчимд цэвэр нямба байх,
 - e. өөрийн болон бусад сурагчийн эд зүйлстэй болгоомжтой хандах,
 - f. хичээлийн бэлтгэлийг хангасан байх, сургуульдаа сурах бичиг болон хэрэгцээтэй зүйлийг цагийн хувиарийн дагуу сургуульдаа авчрах мөн сургуулийн сурган хүмүүжүүлэгчийн зааврыг дагаж мөрдөх, хэрэв эдгээр зүйл дутах нөхцөлд хичээл эхлэхээс өмнө багшаас уучлалт гуйх,
 - g. анги болгонд ажлын болон аюулгүй байдлын дүрмийг баримтлах үүрэгтэй.

Энэ бүх үүргийг сурагч биелүүлэхгүй бол сурагчид сурагчыг шагнах ба сануулага өгөх дүрмийн дагуу сануулага өгнө (хавсралт 1).

2. Сурагчид хориотой зүйлс:
 - a. Хичээл хийж байхад мөн олон нийтийн үйл ажиллагаа явуулаж байхад гар утас хэрэглэхийг хориглоно – гар утсыг унтрааж цүнхэнд хийсэн байна, хэрэв сурган хүмүүжүүлэгчийн тусгай зөвшөөрөлтэй бол энэ дүрмийг харгалзан үзэх хэрэггүй, хэрэв сурагч зөвшөөрөлгүй хэрэглэвэл гар утсыг хураан авч хичээлийн дараа буцааж өгнө, хэрэв дахин дахин сурагч гар утсыг хэрэглэж бусдад саад болсон

тохиолдолд утсыг хураан авч тухайн сурагчын асран хамгаалагчыг дуудаж гар утсыг өгөх болно.

- b. хичээл болон бусад үйл ажиллагаан дээр өөр юм хийх үймүүлэх болон бусдад саад болох,
- c. бусадтай зүй бус харьцах, бүдүүлэг үг хэллэг ашиглах, эсвэл тэднийг шоолох,
- d. шалгалтын явцад хэлж өгөх, бичгийн шалгалт дээр хуулан бичих, хэрэглэх ёсгүй зүйлийг хэргэлэх,
- e. үнэтэй зүйлийг сургуульд авчирх мөн их хэмжээний мөнгө авчрах ёсгүй, шаардлагатай үед сургуулийн конторт хадгалуулах хэрэгтэй.

Дээрх тохиолдлуудаас аль нэгийг зөрчсөн тохиолдолд сурагчид сурагчыг шагнах ба сануулга өгөх дүрмийн дагуу арга хэмжээг авна. (хавсралт 1).

3. Бусад хориотой зүйлүүд:

- a. хичээлийн явцад болон завсарлагаанаар сургуулиас гарахгүй,
- b. тамхи татах, мансуурах ундаа ба энергэт ундааг хэрэглэхгүй,
- c. донтуулах ба хориотой бодис авчрах, хэрэглэх, түүнийг түгээж тараах,
- d. эрүүл мэнд болон амь нас хороох зүйлийг авчрах ба хэрэглэх, жишээ нь зэвсэг мөн салют,
- e. ёс суртахуунд нөлөөлөх зүйл, материалыг авчран тарааж түгээх,
- f. хүчирхийллийг ашиглах, ангийн хүүхдүүдийг доромжлох (хохиороох), арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үл тэвчих байдал гаргах, хүч хэрэглэн биед халдах, өшиглөх, самардах ба цохих,
- g. сургуулийн байранд бэлгийн харьцааны нээлттэй хэлбэрийг дадлагжуулах,
- h. сургуулийн сурган хүмүүжүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр сургуулийн бүх хэсэгт бүх болж байгаа үйл ажиллагааны зураг авах, дүү болон видео хураах хориотой,
- i. ийм материалыг түгээх ба ашиглах (хэсэг h) ялангуяа энд байгаа зураг болон материалыг тухайн хүний зөвшөөрөлгүйгээр ашиглах ёсгүй,
- j. ангийн хүүхдүүд ба сургуулийн ажилчдын талаар доромжлох, гутаан доромжилсон мэдэгдлийг интернет сүлжээгээр түгээх эсвэл хэзээ хаана ямар төхөөрөмжийг ашиглаж байснаас үл хамааран хүний санамсаргүй байдлыг ашигласан.

Энэ тохиолдолд h–j үсгийн дагуу сурагчийн хэрэгслийг хураан авна. Ангийн багшаас хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч өөрийн биеэр ирж авна.

Дээрх дурдсан хориотой зүйлсийг зөрчсөн тохиолдолд сургуулийн дүрэм журмыг бүдүүлэг, ноцтой зөрчсөн гэж үзнэ.

Хууль ёсны асран хамгаалагчийн үүрэг – эцэг эх

1. Сурагчийн хууль ёсны асран хамгаалагчид хүүхдүүдээ цэвэр, зөв хувцасласан, эрүүл чийрэг сургуульдаа ирэхэд нь анхаарч ажиллана. Хэрэв хүүхдэд өвдөх шинж тэмдэг илэрвэл түүнийг гэрийн эмчилгээнд үлдээж, бүрэн эмчилгээ хийлгэх ёстой.
2. Сургуулийн сурагчдын бэлтгэл, зохих ёсоор хичээллэх асуудлыг хууль ёсны асран хамгаалагчид хариуцдаг. Түүнийг цаг хугацаанд нь ирээгүй шалтгааныг баримт болгон бичих (сургуулийн журмын заалт 2-ын дагуу).

3. Хууль ёсны асран хамгаалагчид хүүхдийнхээ боловсролын явцыг тогтмол хянах, сурган хүмүүжүүлэх ажилтнуудтай хамтран ажиллах үүрэгтэй (энэ зорилгоор сурагчийн цахим дэвтрийг голчлон ашигладаг, долоо хоногт нэг удаа шалгаж үзэх шаардлагатай).
4. Ангийн багш, зөвлөх эсвэл сургуулийн удирдлагын хүсэлтээр хууль ёсны асран хамгаалагч хүүхдийн боловсролтой холбоотой ноцтой асуудлыг хэлэлцэхэд биечлэн оролцох үүрэгтэй.
5. Хууль ёсны асран хамгаалагч хүүхдийн эрүүл мэндийн байдал өөрчлөгдсөн эсвэл түүний эрүүл мэнд боловсролын явцад нөлөөлж болох үед тэр талаар тэр даруй сургууль руу мэдээлнэ.
6. Хууль ёсны асран хамгаалагчид Боловсролын тухай хуулийн 28-р хэсгийн 2, 3-р зүйлд заасны дагуу болон боловсролын явцад зайлшгүй шаардлагатай бусад өгөгдөл, эдгээр өгөгдөлд өөрчлөлт оруулах тухай мэдээллийг сургуульдаа мэдэгдэх үүрэгтэй.
7. Хууль ёсны төлөөлөгчид сурагчдын цахим хуудас ном эсвэл сургуулийн вэбсайт дахь хичээлийн цагийн хуваарийн одоогийн өөрчлөлтийг тогтмол хянах үүрэгтэй.

3.4 Сургуулийн харилцан харилцааны дүрэм

1. Сурагчид, тэдгээрийн хууль ёсны асран хамгаалагчид, ажилчид, сургуулийн зочид бие биентэйгээ эелдэг, хүндэтгэлтэй харьцаж, бие биенээ хүндэтгэж, ёс суртахууны дүрмийг дагаж мөрддөг.
2. Бид нээлттэй харилцаа холбоог илүүд үздэг бөгөөд ингэснээр хүн бүрт аюулгүй орчин бүрдэх болно.
3. Сургалтын ажилтнуудаас хууль ёсны асран хамгаалагчид зөвлөгөө авах боломж:
 - a. Хуваарьт ангийн уулзалт, зөвлөгөөний үеэр (хичээлийн жилийн зохион байгуулалт, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу),
 - b. Хувь хүний тохиролцсоны дагуу урьдчилж захиалгаа сурагчийн цахим дэвтэр-еЖК эсвэл утсаар хийх шаардлагатай бөгөөд I хэсэг-павильон дахь төв хаалгаар орж, үүдний жижүүрт, үйлчилгээ үзүүлээгүй тохиолдолд сургуулийн удирдлагатай утсаар ярих шаардлагатай. багш, ангийн нэр, таниас өөрийгөө баталгаажуулахыг шаардаж магадгүй юм.

4 Боловсролын арга хэмжээг магтаж, урамшуулах дүрэм

Энэ бүх магтаал сайшаал, шагнал, боловсролын арга хэмжээг сургуулийн дүрэм журмын дагуу авна. (хавсралт 1).

5 Сурагчдын үнэлгээний дүрэм

Сурагчдын үнэлгээний дүрмийг эдгээр сургуулийн дүрэмд хавсаргав (Хавсралт 2).

6 Сургуулийн өмч хөрөнгөтөй харьцах

1. Сурагч нь сургууль, анги танхимын тоног төхөөрөмж, түүнчлэн хувийн хэрэгцээнд түүнд итгэмжлэгдсэн бүх зүйлийг (жишээлбэл, сурах бичиг) эмх цэгцтэй, гэмтээхгүй байх үүрэгтэй. Сурагчидад сургууль сурах бичиг зээлүүлдэг үүнд болгоомжтой ханддаг.
2. Эд хөрөнгө, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичиг зэргийг санаатайгаар гэмтээсэн тохиолдолд сурагчаар нөхөн төлүүлнэ (хууль ёсны сурагчийн асран хамгаалагч).
3. Сурагч өмч хөрөнгөнд учирсан хохирлыг удирдагч, түүний багш эсвэл сургуулийн бусад ажилтанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

4. Сурагчдад дидактик тоног төхөөрөмжийг ашиглахыг хориглоно. Тэд зөвхөн багшийн зөвшөөрлөөр цонх нээж, наалт ажиллуулж болно.

7 Сурагчдын аюулгүй байдал, хамгаалалтыг хангах нөхцөл

1. Сурагчид хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, галын аюулгүй байдлын талаарх хүчин төгөлдөр дүрмийг даган мөрдөж, зан авираасаа болж тулгарч болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй. Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, галын аюулгүй байдлын талаарх зааварчилгаа сургалт хичээлийн жилийн эхэнд болон шаардлагатай үед явагддаг.
2. Аюулгүй байдлын үүднээс унадаг дугуй, мотороллер, дугуйтай тэшүүр гэх мэтийг сургуулийн орчинд нэвтрэх, хөдөлгөөнд оруулахыг хориглоно. Шаардлагатай үндэслэлтэй тохиолдолд сургуулийн захирал олгодог.
3. Сурагчид зохих хувцас солих өрөөгөөр дамжин сургуульд орж гардаг. Коридорт сурагчдын хяналт болон эрүүл мэндийг сургуулийн үйл ажиллагааны ажилтнууд хамгаалж байгаа тул эдгээр орцоор сургуулийн айлчлалыг хориглоно.
4. Осол гарсан тохиолдолд сурагч (эрүүл мэндийн асуудал гарахад) нэн даруй сурган хүмүүжүүлэх багш, түүний ангийн багш эсвэл удирдагч эсвэл сургуулийн өөр нэг ажилтанд мэдэгдэх үүрэгтэй.
5. Анхны тусламжийн хэрэгсэл нь сурган хүмүүжүүлэх ажилтны кабинет, биеийн тамирын кабинет, сургуулийн хаалгийн манаачид, сургуулийн нарийн бичгийн дарга нарын газар байдаг.
6. Бид нийгэм-эмгэг судлалын үзэгдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлдэг. (сургуулийн урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн дагуу).

8 Өдөр өнжүүлэх

Сургуулийн өдөр өнжүүлэх, клуб нь сургуулийн нэг хэсэг бөгөөд түүний дэглэмийг сургуулийн өдөр өнжүүлэх болон клубын дотоод удирдамжаар зохицуулдаг.

9 Сургуулийн хоолны газар

Сурагчид Ческа Липа хотын 28-р Ржиен гудамжны 2733 тоот бие даасан сургуулийн хоолны газарт хооллох боломжтой. Zrušovaci ustanovení

2016 оны 9-р сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж буй Хавсралт, нэмэлтийг багтаасан сургуулийн дүрмийг хүчингүй болгосон.

10 Эцсийн заалт

Сургуулийн дүрмүүд, түүний дотор хавсралтыг 2020 оны 8-р сарын 26-ны өдөр Сурган хүмүүжүүлэх зөвлөлөөр хэлэлцүүлж, 2020 оны 8-р сарын 26-ны өдөр сургуулийн зөвлөлөөр батлуулав.

Ческа Липа хот, огноо 2020-8-27-нд

Мгр. ба Мгр. Либор Шмейда, МВА

Сургуулийн захирал

Хууль ёсны асран хамгаалагчийн гарын үсэг

Сурагчийн гарын үсэг

.....

.....